



1

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 377

Улаанбаатар хот

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 67.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймгийн захиргааны удирдлагын бүтцийг дараахь байдлаар тогтоосугай.

1.1. Засаг дарга;

1.2. Засаг даргын орлогч (~~жөёрөөс илүүгүй~~);

(Засгийн газрын 2022 оны 263 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

1.3. Засаг даргын Тамгын газрын дарга.

2. Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтцийг дор дурдсанаар тогтоосугай:

2.1. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвтэй);

2.2. Хууль, эрх зүйн хэлтэс (архивын тасагтай);

2.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс;

2.4. Санхүү, төрийн сангийн хэлтэс;

2.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс;

2.6. Нийгмийн бодлогын хэлтэс;

2.7. Цэргийн штаб.

3. Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээнээс хамааруулан Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Завхан, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрыг 46 хүртэл, Булган, Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрыг 42 хүртэл, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрыг 34 хүртэл орон тоотой байхаар тус тус тогтоосугай.

4. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дор дурдсан агентлаг ажиллуулахаар тогтоосугай:

4.1. Байгаль орчин, аялал жуулчлалын газар;

4.2. Биеийн тамир, спортын газар;

4.3. Боловсрол, шинжлэх ухааны газар;

4.4. Гаалийн алба;

4.5. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар;

4.6. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;

4.7. Мал эмнэлгийн газар;

4.8. Мэргэжлийн хяналтын газар;

4.9. Нийгмийн даатгалын хэлтэс;

4.10. Онцгой байдлын газар (хэлтэс);

4.11. Орон нутгийн өмчийн газар (Худалдан авах ажиллагааны албатай);

4.12. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба;

4.13. Соёл, урлагийн газар;

4.14. Стандарт, хэмжил зүйн хэлтэс;

- 4.15. Статистикийн хэлтэс;
 - 4.16. Татварын хэлтэс;
 - 4.17. Улсын бүртгэлийн хэлтэс;
 - 4.18. Ус, цаг уур, орчны шинжилгээний төв;
 - 4.19. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар;
 - 4.20. Хүнс, хөдөө аж ахуйн газар;
 - 4.21. Цагдаагийн газар (хэлтэс);
 - 4.22. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар (хэлтэс);
 - 4.23. Шүүхийн шинжилгээний алба;
 - 4.24. Эрүүл мэндийн газар (Зоонозын өвчин судлалын албатай);
 - 4.25. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс.
5. "Аргачлал батлах тухай" Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын чиг үүргийн шинжилгээг хийж, аймгийн Засаг даргын тамгын газрын хэлтэс, тасаг, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах агентлагийн хооронд чиг үүргийн давхардал, хийдэл үүсгэхгүйгээр оновчтой зохицуулалт хийж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.
6. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржид даалгасугай.
7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 9 дүгээр тогтоол, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 60 дугаар тогтоол, "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 267 дугаар тогтоолын 1 дэх заалт, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 168 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
8. Энэ тогтоолыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.НЯМДОРЖ